



УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 6/09

Улаанбаатар хот

Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх хэсэг, Улсын Онцгой Комиссын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэр, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 102 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/43 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын "Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай" 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 дугаар захирамж, УБИС-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.17 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ төрлийн коронавируст халдварын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан Улсын Онцгой Комиссын шийдвэрийг үндэслэж Монгол улсын Засгийн газрын тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан. Энэ хүрээнд бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгахаар шийдвэрлэсэн тул тус сургуулийн захирлын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/06 тоот "Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай" тушаалыг үргэлжлүүлэн "4 дүгээр сарын 30-ны" өдөр хүртэл сунгасугай.

2. Уг тушаалыг сунгахтай холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэг бүхий шуурхай багийн бүрэлдэхүүний ажиллах цагийн хуваарийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд сургуулийн байранд олон нийтийг хамарсан ямар нэг арга хэмжээ зохион байгуулахгүй байх, спорт заал, хичээлийн анги танхimuудыг зайлшгүй шаардлагаар болон цэвэрлэгээ, ариутгал хийхээс бусад зориулалтаар ашиглахгүй байхыг шуурхай багийн бүрэлдэхүүн, тэнхим, нэгжийн эрхлэгч нарт даалгасугай.

4. Тус хугацаанд бүх түвшний сургалтыг цахимаар үргэлжлүүлэх тул хичээл, сургалтыг батлагдсан хуваарийн дагуу чанартай, үр дүнтэй зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Сургалт эрхэлсэн дэд захирал /Г.Анхбаяр/-д, мөн тус хугацаанд багш, оюутнуудын хичээл, дадлагын үйл ажиллагааг тасалдуулалгүй хөтөлбөр, хуваарийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулж, багш, оюутныг цахим хичээлд хамрагдах нөхцөл бололцоог хангаж, хичээлийн ирцэд онцгой анхаарч, цаг тухайд нь шуурхай арга хэмжээ авч ажиллахыг бакалаврын сургалтын алба /нийт мэргэжилтнүүд/-д, Магистр, докторын сургалтын алба /Х.Сүглэгмаа/ нарт тус тус даалгасугай.

5. УБИС-ийн нийт оюутан, багш ажилтнуудад халдварт өвчинеэс урьдчилан сэргийлэх, дархлаагаа сайжруулах чиглэлээр Засгийн газар, ЭМЯ, ДЭМБ, БСШУСЯ, бусад холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөгөө, мэдээллээр хангах, шуурхай багийн бүрэлдэхүүнийг удирдлага, чиглэлээр хангаж ажиллахыг шуурхай багийн ахлагч, хүний нөөцийн албаны дарга /Б.Энхбаатар/-д даалгасугай.

13201060

6. Аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг зохих журмын дагуу тасалдуулахгүй явуулах, хөл хорионы хугацаанд багш, ажилтнуудын цалинг зохих ёсоор олгохыг Санхүү, эдийн засгийн албаны дарга, нягтлан бодогч /О.Туяа/-д зөвшөөрсүгэй.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /Б.Энхбаатар/-д, ажил үүрэгтээ мөрдлөг болгож ажиллахыг нэгжийн удирдлагууд, нийт багш ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



(Sc.D), проф С.БАЙГАЛСАЙХАН

Улаанбаатарын их сургуулийн захирлын
2020. оны 02 дугаар сарын 26.-ны
өдрийн *М.Ожигийн* тоот тушаалын хавсралт

9596508 1117143083

Хөл хороо тогтоосон хугацаанд хариуцлагатай жижүүрээр ажиллах
шуурхай багийн бүрэлдэхүүн

Д/д	Овог нэр	Албан тушаал	Хариуцлагатай жижүүр хийх хугацаа	Утасны дугаар
1	Ц.Отгонжаргал, Б.Энхбаатар	Багшийн хөгжлийн төвийн эрхлэгч, Хүний нөөцийн албаны дарга	2020.03.30- 2020.04.03	91992713 11-453567, 88104940
2	Г.Анхбаяр Х.Сүглэгмаа	Сургалт эрхэлсэн дэд захирал, Магистр, докторын сургалтын албаны дарга	2020.04.06- 2020.04.10	11-456360, 99892298 11-458322, 99088980
3	С.Цолмон О.Туяа	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Санхүү, эдийн засгийн албаны дарга	2020.04.13- 2020.04.17	11-453554, 99150021 11-457049, 99041988
4	Д.Ганцогт Л.Бат-Эрдэнэ	Чанарын дотоод баталгаажуулалт, маркетингийн албаны дарга, Аж ахуйн дарга	2020.04.27- 2020.05.01	88081245 11-458322, 99088980

ЖИЧ: Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд шуурхай багийн бүрэлдэхүүн нь тухайн хариуцсан 7 хоногтоо тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажил үйлчилгээ болон онлайн хичээл сургалтыг тасалдуулахгүй явуулах нөхцөл бололцоог хангуулах, холбогдох тэнхим, алба, нэгжүүдийг шаардлагатай мэдээллээр хангаж, шаардлагатай тохиолдолд шуурхай багийг цуглуулж асуудлыг шийдвэрлүүлэх үүргийг хүлээнэ.